

ХҮНИЙ ЭРХ ХӨГЖИЛ ТӨВИЙН 2021 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

I. ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

ГАЗРЫН ТУХАЙ БАГЦ ХУУЛИЙН ТӨСӨЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Барилга хот байгуулалтын яам (БХБЯ)-аас Газрын тухай багц хуулийг шинэчлэн боловсруулж, Багц хуулийн төсөлд дараах таван хуулийн төсөл орсон юм. Үүнд:

1. Газрын ерөнхий хуулийн төсөл (шинэчилсэн найруулга);
2. Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хуулийн төсөл;
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга);
4. Кадастрын тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга);
5. Газрын төлбөрийн тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга).

Иймээс ТНС байгууллагын санаачлага, дэмжлэгээр Хүний эрх хөгжил төв Газрын тухай багц хуулийн төсөлд шаардлагатай асуудлаар нөлөөлөх үйл ажиллагаа 2021 оны 5-р сард хэрэгжүүлж эхэлсэн. Уг **төслийн зорилго нь:** Газрын тухай багц хуулийн төсөлд байгаль орчин, иргэдийн оролцоог хамгаалах, хангах заалтуудыг сайжруулах хоёр зорилтыг хэрэгжүүлэхэд оршив. Үүнд:

1. Хуулийн төсөлд байгаль орчинг хамгаалах, иргэдийн оролцоог хангах санал, саналын үндэслэл, томъёоллыг боловсруулах;
2. Боловсруулсан саналыг хуулийн төсөлд тусгуулахад нөлөөлөх.

Төслийн хүрээнд, үр дүн: Эрсдэлтэй зүйл заалтын өөрчлөлт, хасалтын тухай саналыг ажлын хэсэгт олон хүнээр өгүүлэх ажил зохион байгуулсан. Үүний тулд Ажлын баг эрсдэл бүхий зүйл заалтыг хасах, өөрчлөх тайлбар, үндэслэл бүхий саналыг Улаанбаатар хот, Дорнод, Хэнтий аймгийн төв, Баяндун, Биндэр зэрэг сумд дахь ХЭХТ-ийн харъяа нутгийн иргэдийн бүлэг, холбоодын ахлагчид, гишүүдэд танилцуулж БХБЯ-ны газрын тухай багц хуулийн төсөлд цахимаар санал өгөх цахим уулзалт, сургалтыг 3 удаа зохион байгуулж санал өгөхөд нь дэмжин ажилласан.

Энэ ажлын үр дүнд орон нутгийн бүлгийн гишүүдээс 2021 оны 5 сарын 18-ны өдрөөс 2021 оны 5 сарын 21 дотор нийтдээ давхардсан тоогоор 94 санал өгсөн болно.

Эдгээр саналыг агуулгаар нь ангилбал дараах асуудлаар хуваагдаж байна. Үүнд:

1. Тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой санал - 29
2. Өвөлжөө, хаваржаа, бэлчээр, хадлан, тариалангийн талбайтай холбоотой – 18
3. Иргэдэд мэдээлэл хүргээгүйг шүүмжилсэн санал – 7
4. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой санал – 4
5. Уул уурхайтай холбоотой санал -9
6. Газар зохион байгуулалттай холбоотой санал – 7
7. Газар нутгийн нэр, зарим нэршил, үгтэй холбоотой - 7
8. Оролцооноос бусад хүний эрхийн асуудалтай холбоотой санал - 9
9. Нөхөн төлбөртэй холбоотой санал – 2
10. Усны сан, түүнтэй холбоотой санал – 2

11. Бусад - 3 санал өгсөн байна.

Мөн төслийн баг ТАН эвсэл, Хүний эрхийн форум (ХЭФ) зэрэг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран олон талын оролцоотой бүсчилсэн цахим уулзалтыг зүүн болон говийн бүсэд 6 сарын 29, 7 сарын 6-нд тус тус зохион байгуулсан. Эдгээр уулзалтад аймаг, сумдын ЗДТГ-ын хуулийн хэлтэс, хуулийн ажилтан, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Газрын алба, газрын асуудал хариуцсан ажилтан, Байгал хамгаалах газар, байгал хамгаалагчид, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд, иргэдийн бүлгийн төлөөллийг хамруулсан нийт 400 гаруй хүмүүс оролцсон.

Хэлэлцүүлгээр Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын Газрын албантшаалтнуудаас хуулийн төсөлд өгсөн саналын тухай танилцуулга хийлгэсэн. Мөн хуулийн төсөлтэй хамаатай уул уурхайн үйл ажиллагаа, байгаль орчны хамгаалал, тусгай хамгаалалттай газар нутаг, газар чөлөөлөх болон иргэдийн мэдэх, оролцох эрхтэй хамаатай асуудлыг хөндсөн танилцуулгыг иргэний нийгмийн төлөөлөгчдөөс хийсэн болно

Төслийн хүрээнд хуулийн төслийн онцлох асуудлаар постер бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээх, дэмжлэг авах ажлыг хийлээ. Хуулийн төслөөс онцлох долоон асуудлыг сонгон постерын агуулгыг боловсруулж хоёр хувилбараар бэлтгэн Хүний эрх хөгжил төвийн (Centre for Human Rights and Development) нүүр хуудасанд 9 дүгээр сарын 16-нд байрлуулав. Одоогоор эхний хувилбар 3370 гаруй хүнд хүрч, 65 нүүр хуудасд шейрлэгдсэн бол хоёр дох хувилбар 14,106 хүнд хүрч, 90 нүүр хуудасд шейрлэгдсэн байна.

ОЛОН НИЙТИЙ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ТӨСӨЛ /UNDP/

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай хүртээмжтэй хүргэх нөхцлийг бүрдүүлж иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан цахимаар үзүүлэх үйлчилгээний тоо төрлийг нэмэгдүүлэх, цахим Монгол хөтөлбөрийг хэрэгжүүлэн хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай болгох зорилт тавьсан. Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний цахим машин”, “Цахим Монгол” зэрэг шинэ арга, технологийг үйл ажиллагаандаа ашиглан нэвтрүүлэхээс гадна иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлж байгаа боловч өнөөдөр төрийн үйл ажиллагаа, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж үйлчилгээнд тавих олон нийтийн хяналт хангалтгүй, хууль, журмын зохицуулалт нь амьдралд хэрэгжүүлэх бодит нөхцөл, боломжийг тооцоогүй, зохицуулалт өөр хоорондоо зөрчилтэй, хэрэгжилтийн талаарх мэдээлэл, судалгаа, бүртгэл байхгүй, хэрэгжилтийг хангах арга хэмжээ аваагүй нөхцөлд тооцох хариуцлага тодорхойгүй байгаа хэмээн дүгнэсэн байна.

Иймд нэгдсэн арга зүйгээр хангах, олон нийтийн хяналтыг төрийн үйлчилгээний төрөл, салбарын онцлогт нийцсэн байдлаар төрөлжүүлэн хөгжүүлэх хэрэгцээ нь “Төрийн албаны олон нийтийн хяналтын зөвлөл”- ийг яаралтай байгуулж, үйл ажиллагааг нь жигд, тогтвортой байлгах шаардлага гарсан. Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийг батлахдаа зөвлөлийн чиг үүрэг, эрх хэмжээ, бүтэц бүрэлдэхүүн, тавигдах шаардлага, хяналтын хэлбэр, үйл ажиллагааны журам зэргийг хуульд нийцүүлэн нарийвчлан тогтоох шаардлагатай байна.

ХЭХТ нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Төрийн үйлчилгээний үр дүнтэй байдлын талаарх (гадаадын болон үндэсний) хууль эрх зүйн бичиг баримтууд болон төрийн албыг үр дүнтэй ашиглах шилдэг туршлага, баталгааг судлахаас гадна төрийн албаны олон нийтийн хяналтын зөвлөлийн дүрмийн төсөлд оруулах саналыг боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлэн саналуудыг авч уламжлан хүргүүлсэн болно. Нийт 8 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, 100 гаруй иргэд хамрагдсан байна. Тус хэлэлцүүлгүүдийг цахимаар болон танхимаар амжилттай зохион байгууллаа.

ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ

Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засагт нөлөө бүхий хөгжлийн төслүүдийг хариуцан хэрэгжүүлж байсан, эсхүл өндөр үнийн дүнтэй гэрээ хэлцэлд оролцсон улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан эсхүл сонгуульд оролцохоор нэр дэвшүүлсэн хүмүүсийн эсрэг хэрэг үүсгэн шүүхээр шийдвэрлэж байна. Монгол Улсын хувьд авлигад идэгдсэн, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцдоггүй, шударга бус байдал тогтолцоожсон байгаа энэ цаг үед авлига, албан тушаалын гэмт хэргийг илрүүлж, таслан зогсоох, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох нь зайлшгүй чухал алхам болно.

Гэхдээ шударга ёсыг тогтоох нэрийн доор хэн нэгний эсрэг улс төрийн тооцоо хийх зорилгоор шүүхийг ашиглаж байна, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг алдагдуулж байна, шүүх үйл явц хууль тогтоомжийн дагуу явахгүй байна гэсэн хардлага, эргэлзээ мөн нийгэмд үүсээд байна. Үүний зэрэгцээ хэрэгт холбогдсон зарим хүмүүс хүний эрх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэм хэмжээ алдагдаж байгаа тухай гомдол гаргах болсон байна.

Иймээс Хүний Эрх Хөгжил Төв нь энэхүү эргэлзээг арилгах зорилгоор тодорхой шийдвэрүүдэд хүний эрхийн болон эрх зүйн дүн шинжилгээ бүхий мэргэжлийн дүгнэлт гаргуулан өөрсдийн байр суурийг олон нийтэд хүргэхээр санаачлага гарган ажиллаж байна. Энэ санаачлагыг 2020 оны 9 дүгээр сарын 4-ний өдөр зохион байгуулсан Хүний эрхийн Форумын нийт гишүүдийн хурлаар дэмжсэн шийдвэр гарсан.

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зорилго нь улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан хүмүүсийн холбогдсон авлига, албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх замаар үүсээд буй нөхцөл байдалд хүний эрхэд суурилсан дүгнэлт хийж, байр сууриа олон нийтэд илэрхийлэхэд оршино.

Шүүхийн шийдвэрт хийх эрх зүйн дүн шинжилгээг шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлалын¹ дагуу, хүний эрхийн дүн шинжилгээг халдашгүй байх, шударга шүүхээр шүүлгэх эрх²-ийн хүрээнд хийх бөгөөд дүн шинжилгээ нь дараах үнэлгээний асуултад хариулсан болно. Үүнд:

¹Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал, 2015 он, <https://www.judcouncil.mn/file/taraah.pdf>


²Иргэний улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 9, 10, 14, 15-р зүйл, 1966 он, Хүний эрхийн хороо, Ерөнхий зөвлөмж №35, 2014, CCPR/C/GC/35, Ерөнхий зөвлөмж №32, 2007, CCPR/C/GC/32,

1. Баривчлах, цагдан хорих, батлан даалтад авах зэрэг арга хэмжээг хуулийн хүрээнд авсан эсэх
2. Мөрдөн шалгах ажиллагаа хуулийн хүрээнд явагдсан эсэх
3. Гэм буруугүйд тооцогдох зарчим мөрдөгдсөн эсэх
4. Хууль зүйн туслалцаа авах эрх хангагдсан эсэх
5. Зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдсэн эсэх
6. Шүүх хурлын явцад тодорхой болсон нэмэлт нотлох материал, хохирогч, гэрчүүдийн мэдүүлэг шүүхийн тогтоолд тусгалаа олсон эсэх
7. Яллагдагчаар татсан эрүүгийн хэрэг, шүүхийн шийдвэрээр ял оногдуулсан эрүүгийн хэргийн хооронд эргэлзээ төрүүлэхүйцэрүү үүссэн шүүх ажиллагааны баримт буй эсэх
8. Хууль хэрэглээний болон эрх зүйн онолын маргаантай
9. Бусад эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн эсэх

Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний тайлан, хэлэлцүүлгийн шүүмж өмгөөлөгчөөс нэмэлт мэдээлэл авч тайланд тусгасан болно.

- **Тайлангийн хэлэлцүүлэг зохион байгуулж, шинжилгээний дүнг танилцуулах, оролцогсдоос гарсан санал зөвлөмжийг хавсарган холбогдох албан байгууллагуудад илгээх ба Хүний эрхийн форумын вэб, хүүр худсанд байрлуулах болно.**

II. СУДАЛГАА - Цар тахалын үед дэх Хүнсний эрхийн Тандалт судалгаа



Жил бүр Дэлхийн Хүнсний өдрийг 10-р сарын 16-нд тэмдэглэдэг уламжлалтай.

Энэ жил Иргэний нийгмийн байгууллагууд Хүнсний өдрийг “ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨНГИЙН ӨДӨР” болгон тэмдэглэсэн. Учир нь Дэлхий даяар өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Иймд Хүнс Эвсэл ТББ, ХЭХТ хамтран хүнсний эрхийн тандалт судалгааг УБ хотын СХД, Хан-Уул, Баянгол, Баянзүрх дүүргүүд болон Говь-Алтай, Өвөрхангай, Төв, Дорнод аймгийн Баяндун, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нийт 200 гаруй иргэдээс судалгаа авлаа. Энэхүү тандалт судалгаанд зорилтот бүлгийн нэн ядуу, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд мөн өрх толгойлсон иргэд оролцов. Судалгаанд хамрагсад хүнсний эрх хэрхэн хэрэгжиж байгаа, цар тахлын үед орлого хэрхэн өөрчлөгдсөн, ямар хүндрэл бэрхшээлүүдтэй тулгарч буй талаар мөн өөрсдийн амьжиргааг хэрхэн үнэлж байгаа талаар ярилцаж, кейс баримтуудыг баримтжуулж авлаа. Мөн тус судалгаанд оролцсон

хүмүүс төр засаг, хувийн хэвшилүүдэд хандаж өөрсдийн дуу хоолойгоо хүргэж байгааг Та бүхэнд танилцуулж байна. Энэ жилийн уриа нь: - ХҮНСНИЙ СИСТЕМИЙГ ӨӨРЧИЛЬЕ!
 - АЮУЛГҮЙ, ТЭЖЭЭЛЛЭГ ХООЛ ХҮНС АВАХ ЭРХЭЭ ЭДЭЛ!
 - ПЕСТИЦИДИЙН ХЭРЭГЛЭЭГ ЗОГСОО!
 - МОНОКУЛЬТУР БИШ ХҮНСНИЙ ОЛОН ЯНЗ БАЙДЛАА ХАДГАЛ!

ЦАР ТАХАЛЫН ҮЕД ЗОРИЛТОТ БҮЛГҮҮДЭД ТУЛГАМДАЖ БҮЙ ХҮНДРЭЛҮҮД:

- АЖИЛ ЗОГССОН, АЖИЛ ОЛДОХГҮЙ /НАС .ХҮЙС ЗААДАГ/
- ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ БАГА
- КОМПАНИУД ЦАЛИНГАА ӨГДӨГГҮЙ, АЖЛЫН ЦАГ УРТ
- БАНКНЫ ЗЭЭЛИЙН ХҮҮ ӨНДӨР, АЛДАНГИ ИХ
- ХҮНСНИЙ ҮНЭ ӨНДӨР /МАХ/, ЧАНАР МУУ
- ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ АЖИЛД АВДАГҮЙ
- ХҮНСНИЙ ТАЛОН ХҮРТЭЭМЖГҮЙ, ИЛ ТОД БИШ
- ХУДАЛДАН АВАХ ХЭМЖЭЭ БУУРСАН/ГРАММААР АВДАГ/ НЭР ТӨРӨЛ ЦӨӨРСӨН/ЦУВДАА, ЖИЖИГЛЭН/

ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙ

ТӨР ЗАСАГТ

- ХҮНЭЭ БОДСОН, ОНОВЧТОЙ ЗӨВ ШИЙДВЭР ГАРГАХ
- БАЙНГЫН ТОГТМОН АЖИЛ, АЖЛЫН БАЙРЫГ БИЙ БОЛГОХ /УЛСЫН ҮЙЛДВЭР БАРИХ/
- ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛЖ ХИАЛТАНДАА БАЙЛГАХ
- ХҮНСНИЙ ТАЛОНЫГ ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ХҮРТЭЭМЖТЭЙ ИЛ ТОД, ХИАЛЛТАЙ ОЛГОХ
- ЯДУУРЛЫГ УСТГАЖ, ХҮНСНИЙ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛ!
- БУСДААС ХАМААРАХГҮЙ УЛС ОРНОО АВЧ ЯВАХ!

ХУВИЙН СЕКТОРТ

- ХӨДӨЛМӨРИЙН МӨЛЖЛӨГӨӨ ЗОГСОО!
- ЦАЛИНГАА ӨГӨХ, НЭМЭХ, АЖЛЫН ЦАГИЙГ БАГАСГАХ, ШУНАЛАА ТАТ!
- ҮНЭ ХӨРӨГДӨХӨӨ ЗОГСОО!
- ХӨДӨЛМӨР ХАНГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАЖ АЖИЛЛАХ
- НАС, ХҮЙС, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛЭЭР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГҮЙ БАЙХ

ХУВЬ ХҮН ӨРӨӨ

- ХАРИУЦЛАГАТАЙ БАЙ
- АЛЬ БОЛОХ ХЭМНЭ, ХИЧЭЭ, БАГА ЗАРДЛААР АМЬДАР
- ХҮНИЙ ГАР ХАРАХГҮЙ, ХҮЧТЭЙ БАЙ /ӨӨРИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ/

"МОНГОЛ ЭМЭГТЭЙН ОРОН НУТАГТАА ХИЙСЭН ӨӨРЧЛӨЛТИЙН ТҮҮХ ОЛОН УЛСАД"

local Governor's office initially refused to share information and engage with the team. In 2019, Munkhzuul finally found the avenue to share the findings and recommendations of her team's research at the National Dialogue on the "Sustainable Development Goals and Our Participation", held in Ulaanbaatar. Representatives of local authorities and decision-makers attended the National Dialogue and were able to respond to the recommendations made by her team. The work was well-received, and she was invited as a guest speaker on local TV. Encouraged by her team, she decided to accept the invitation.

She was so proud when other community members told her they saw her live, she felt like a whole different person when speaking on TV! Since then, local authorities and community members understood her team's work better and started supporting the initiatives.

The Governor of the Dornod province proposed to her to run as the Citizen's Representative of Khural. She ran for the local election in October 2020 and, although she didn't win a seat, the whole experience was very gratifying for her.

With financial support from the Better World humanitarian organization and the Red Cross, Munkhzuul's team has now received land permission from the Governor to build a Community Development Centre. Currently, they're planning to establish two to three workshops at the center to contribute to decreasing poverty in their soum. During the pandemic they formed the newly-granted land and provided impoverished people with fresh vegetables.

The most important thing that I learned participating in the Women2030 program is the power that comes when people can take part in the development of their communities and the importance of expressing people's needs to the local authorities in a strategic way. I also understood that the work isn't only that of demanding from the local authorities. We can also contribute new understandings around the Sustainable Development Goals. We carried out research that can support many different stakeholders, including local government officials and people in neighboring villages".

Sarenkhukhuu Shierandorj

Munkhzuul's story highlights traditional gender stereotypes as root causes of gender inequality.

The story stresses how gender stereotypes limit women's visibility and political participation. Global frameworks aimed at advancing women's political participation and programs that strengthen women's leadership and civil society feminist movements can contribute to tackling these root causes.

Munkhzuul's story is an example of how the Women2030 program supported women to develop their leadership.

The Partners implementing the Women2030 program proposed various activities to develop women's capacities to recognize their aspirations and work towards them. Practically, this took on different forms. You will read a few more examples in this booklet, such as: providing training on women's rights and gender equality; supporting the creation of income-generating activities; enabling the establishment of women-led forest protection groups; delivering awareness-building on global development frameworks such as Agenda2030 and the SDGs.

When women can channel their own power, they become more comfortable navigating power structures.

Women2030 Partners placed a strong focus on confidence-building activities. Women channelled this confidence in their unique ways to develop their potential. For example, they became more independent in their own families, set up income-generating activities, or acted as leaders in their communities.

AREAS OF IMPACT
Capacities Built, Policies Improved.

In your context, what barriers are limiting people's active participation in local development?

Which strategies are women's groups developing to overcome these barriers and participate actively?

Хүний эрх хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож (Urantsooj Gombosuren)-ийн үргэлж хэлдтээр "Хөгжил хүний төлөө, хүний оролцоотой явагдах ёстой" зарчмын дагуу Олон улсын хөгжлийн үйл явцад орон нутгийн иргэдийг татан оролцуулах, дуу хоолой болох, орон нутгийн удирдлагуудтайгаа хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж, чадавхийг нь нэмэгдүүлэх замаар Тогтвортой хөгжлийн зорилгуудын (ТХЗ) хэрэгжилтийг ахиулахад хувь нэмэр болох зорилготой ажилласаар байна. ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой олон улсын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн бөгөөд, 4

жилийн хугацаанд 17 улсын 123 байгууллагуудад санхүүжилт олгогдсоноос үр нөлөө өндөртэйгээр хэрэгжсэн 14 төслийн нэгт багтсан нь хэвлэгдэн гарчээ. Үүнд ХЭХТ-ийн харьяа Дорнод аймгийн Баяндун суман дахь Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн холбооны дарга Я.Мөнхзул болон ажлын хэсгийн гишүүд, төр болон жирийн иргэд хамтарч нөлөөллийн ажлууд хийн өөрсдийн асуудлуудыг шийдвэр гаргагч нарт хүргэн асуудлаа шийдүүлж, өөрсдийгөө өөрчилж чадсан тухай амжилтын түүхээ бичин өгүүлсэн байна. Тус түүх нь англи хэлнэ хөрвүүлэн гарсан. Хэрэв Та бүхэн бүтнээр нь уншихыг хүсвэл => "A Booklet of impact stories" - <https://www.women2030.org/.../2021/06/booklet-EN-resized.pdf>

ХЭХТ-ИЙН ХАРЬАА МХБ БҮХ ГИШҮҮДИЙН 15 ДАХЬ ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ ЦАХИМ УУЛЗАЛТ

Энэ жил бүх гишүүдийн 15 дахь Туршлага солилцох уулзалтыг 2021 оны 07-р сарын 26-нд цахимаар амжилттай зохион байгууллаа. Тус уулзалтанд нийт 81 бүлгийн гишүүд оролцлоо.

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН ӨДӨРТ ЗОРИУЛСАН “ЭРХЭЭ ШААРДЬЯ” ЦАХИМ АЯНД НЭГДЭЦГЭЭ



12-р сарын 9-ны өдөр ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫГ ХАМГААЛАХ ӨДӨР





“Эрхээ шаардъя” цахим уулзалт 2021 оны 12-р сарын 9-ны өдөр зохион байгуулж УБ, Дархан, Өвөрхангай, Дорнод, Хэнтий, Баяндуг, Мөрөн сумын нийт 80 гаруй бүлгийн гишүүд, хүний эрхийн хамгаалагчид оролцов. 2021 оны 4 дүгээр сарын 6-нд Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж 7-р сарын нээс хүчин төгөлдөр үйлчлэх болсон. Монгол улс нь хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах бие даасан хуультай Ази тивийн анхны улс болсон юм. Энэ хуулиар хүний эрх хамгаалагч гэж хэн болох, хүний эрхийн хамгаалагчийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжихэд төрийн албан хаагч ямар үүрэгтэй болох, хүний эрх хамгаалагч хүний эрхийн үйл ажиллагаа хийж байгаад аюул заналхийлэлд өртвөл ямар хамгаалах механизмыг байгаа тухай тус цахим уулзалтаар таниулах зорилготой байв.

Тус цахим уулзалтаар Хүний эрхийн Хамгаалагч гэж хэн бэ? ХЭХТ-ийн Тэргүүн Г. Уранцоож болон Хүний эрхийн хамгаалагчид доорх сэдвүүдээр илтгэл тавьж ярилцлаа.

Эрхээ шаардагч:

- **Хүнсний эрх** - Г. Оюунтуяа, “Хүнс Эвсэл” ТББ-ийн Тэргүүн
- **Хүүхдийн эрх** - Ц. Оюунчимэг, УБ хотын МХБХ-ны дарга
- **Эрүүл мэндийн эрх** – Д. Сарангуа, УБ хотын МХБХ-ны Хамт Олныг Хөгжүүлэх сангийн зохицуулагч
- **Эмэгтэйчүүдийн эрх** - Я. Мөнхзул, Дорнод амйгийн Баяндун сумын МХБХ-ны дарга
- **Ахмадын эрх** – Даваа, Өвөрхангай аймгийн “Солонго” бүлгийн гишүүн
- **Гэр бүлийн хүчирхийлэл** – С. Сарангэрэл “Ивээл” бүлгийн ахлагч
- **Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх** – Д.Уранчимэг, Хэнтий аймгийн МХБХ-ны дарга

12-р сарын 10-ны ӨДӨР ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ӨДӨР тохиодог билээ. Жил бүр ХЭФ-ын гишүүн байгууллагууд хамтран тэмдэглэдэг уламжлалтай. Энэ жилийн хувьд “Эрхээ шаардъя” цахим аян өрнүүлж цуврал арга хэмжээнүүд зохион байгуулж сошилоор олон нийтэд хүргэсэн. Энэ ажлын хүрээнд Хүний Эрх Хөгжил Төв (ХЭХТ) Монгол улсад Иргэний орон зай ямар байгаа талаар хот, хөдөө орон нугийн 100 гаруй ТББ, иргэний байгууллагуудаас цахимаар судалгаа авч удахгүй Та бүхэнд танилцуулах болно.



III. Хүний эрхийн тухай VIDEO-уудыг бэлтгэн гаргалаа. Үүнд:

1. Олон улсын Хүний эрхийн өдрийг угтсан видео /A24 News Agency /
2. “Хүнсний Эрхээ хэрэгжүүлцгээе!”

3. “Тогтвортой Хөгжлийн зорилго ба Хүний эрх”

Та бүхэн манай FB-ээс үзэх боломжтой:

https://www.facebook.com/chrdmongolia/?ref=page_internal

IV. Хэвлэж гаргасан

I. ЦАХИМ СУРГАЛТ, УУЛЗАЛТ, ХУРАЛУУД

- СУУРЬ ОЙЛГОЛТ ГҮНЗГИЙРҮҮЛЭХ ЦУВРАЛ СУРГАЛТ /MONFEMNET/ 2021 оны 3-р сарын 2-5ны хооронд – хүний эрх, эрхэм чанар, хүний эрхэд суурилсан хандлага, тэгш оролцоо, хамтын манлайлал, бодлгын нөлөөлөл
- APWLD Зүүн Азийн дэд бүсийн хорооны хурал / **East Asia Sub regional Committee meeting / 2021 оны 3-р сарын 15/**
- **APRN “НӨЛӨӨЛӨЛ БА ОРОЛЦОО”** цахим сургалт / 2021 оны 4-р сарын 26-29/ 5 хүн монголоос оролцлоо /Дархана, Дорнод, Хэнтий, УБ/
- APWLD гишүүн байгууллагуудын Зүүн Азийн Хуралдаан / East Asia Convening Annotated Programme /2021 оны 5-р сарын 10-12/ Systemic Challenges in East Asia, Asia and the Pacific.
- APWLD Ерөнхий Ассамблей / **APWLD General Assembly /2021 оны 6-р сарын 21-23/** Стратеги боловсруулж хэлэлцүүлэх, дараагийн алхамууд/
- 15 дахь UNCTAD Иргэний Нийгмийн чуулга уулзалтанд оролцож “Цар тахал 19 response related to fiscal space”



ОЛОН УЛСЫН КАМПАНИТ ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЭГДЭЖ ӨӨРСДИЙН ДУУ ХООЛОЙГОО
ӨРГӨЛӨӨ

